



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ ТӨРӨӨС ОЛГОХ НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ
/Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настан, гавьяат цолтон
ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ/

2008 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 33

Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд
төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол
Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн хэмжээг 200,000 /хоёр зуун мянга/, гавьяат цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг 2008 оны төсвийн тодотголд тусган шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН
